



“Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны  
2 дугаар сарын 17 өдрийн хурлаар батлав.

## “ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид “Хороо” гэх) баталсан “Хувьцаат компанийн засаглалын кодекс” болон Компанийн тухай хууль, журамд нийшүүлэн компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хувь нийлүүлэгчид болон олон нийтэд түгээх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 “Мэдээлэл” гэдэг нь, “ШАРЫН ГОЛ” ХК-ийн талаарх бичиг баримт болон олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулсан үйл ажиллагааг хэлнэ. Үүнд:
- 1.2.1 Компанийн (хагас, бүтэн жилийн) тайлан тэнцэл
  - 1.2.2 Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын шийдвэр
  - 1.2.3 Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр
  - 1.2.4 Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл
  - 1.2.5 ТУЗ-ийн болон эрх бүхий албан тушаалтны танилцуулга
- 1.3 “Мэдээлэл түгээгч” гэдэг нь хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтан болон эрхэлж буй ажил, албан тушаалтын дагуу үнэт цаас гаргачийн талаарх мэдээлэл эзэмшигчээр тогтоогдсон гэдгийг хэлнэ.

### Хоёр. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл түгээх үүрэг

- 2.1 Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, компанийн албан ёсны шийдвэр гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд, шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалатнд тооцно.
- 2.1.1 Нийтэд хүргэх мэдээллийг компанийн вэб сайтад давхар байршуулахаас гадна компанийн ажлын байрнаас хэдийд ч саадгүй авах боломжийг хангасан байна.
  - 2.1.2 Мэдээллийг нээлттэй, ил тод болгох үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:
    - 2.1.2.1 Тогтмол байх
    - 2.1.2.2 Компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогч өусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх
    - 2.1.2.3 Үнэн зөв, тодорхой, ойлгомжтой байх
    - 2.1.2.4 Агуулгын хувьд хоёрдмол санаагүй, бүрэн дүүрэн байх
    - 2.1.2.5 Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх

- 2.1.2.6 Хувьцаа эзэмшигчид мэдвэл зохих өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаахгүй байх
- 2.1.3 Мэдээллийг ил тод болгох ажиллагааг Гүйцэтгэх удирдлага эрхлэн явуулах бөгөөд түүний үйл ажиллагаанд ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 2.1.4 Хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон мэдээллээс гадна дор дурьдсан мэдээллийг нийтэд мэдээлнэ:
- 2.1.4.1 Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын тухай болон тэдгээр нь өөрчлөгдсөн тухай мэдээлэл
- 2.1.4.2 Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тухай мэдээлэл
- 2.1.4.3 Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр этгээд нь компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол/
- 2.1.4.4 Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл
- 2.1.4.5 Компанийн томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын тухай мэдээлэл
- 2.1.4.6 Компанийн хараат, охин компанийн тухай мэдээлэл
- 2.1.4.7 Компанийн халаасны хувьцааны тухай мэдээлэл
- 2.1.4.8 Компанийн нэр, төв захиргааны оршин байх газар өөрчлөгдсөн тухай мэдээлэл
- 2.1.4.9 Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэл
- 2.1.4.10 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээлэл
- 2.1.4.11 Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн
- 2.1.4.12 Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай
- 2.1.4.13 Компанийн хувь нийлуулсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/-г нэмэгдүүлэх, хорогдуулах төслийг ТУЗ баталсан
- 2.1.4.14 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан тухай
- 2.1.4.15 Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ юмуу хуульд заасан тохиолдолд хувь нийлуулэгчдийн хурал баталсан тухай
- 2.1.4.16 Компанийн үл хөдлөх хөрөнгийн 10-аас дээш хувийг худалдсан, барьцаалсан, ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл
- 2.1.4.17 Компанийн үйл ажиллагаа, хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн
- 2.1.4.18 Төрийн болон орон нутгийн өмчлөлд байсан компанийн хувьцааны хяналтын багц хувьд шилжсэн
- 2.1.4.19 Компанийг хуульд заасан хэлбэрээр өөрчлөн байгуулах төслийг ТУЗ баталсан
- 2.1.4.20 Нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргах төслийг ТУЗ, хувь нийлуулэгчдийн хурлаар баталсан тухай мэдээлэл

- 2.1.4.21 Компанийн санхүүгийн тайлан, төрийн зохицуулалтын байгууллагаас тогтоосон нэмэлт, тайлбар тодруулгын хамт
- 2.1.4.22 Компанийн үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийдгэсэн тухай тайлан
- 2.1.4.23 Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, лицензийг худалдсан, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай
- 2.1.4.24 Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл

#### **Гурав. Мэдээллийг боловсруулах, түгээх**

- 3.1 Мэдээллийг холбогдох алба буюу албадын хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн зөв эх сурвалжуудыг ашиглан боловсруулах ба компанийн цахим хуудас, холбоо харилцааны хэрэгслүүд, биечилсэн уулзалт, олон нийтийн мэдээллийн сувгуудын нэгийг буюу хэсгийг ашиглан үнэн зөв мэдээллүүдийг хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүргэнэ.
- 3.2 Олон нийтэд түгээх үүрэгтэй мэдээллийг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, эсвэл ТУЗ, Гүйцэтгэх удирдлагаас томилогдсон ажилтан холбогдох албадтай хамтран бэлтгэж, холбогдох байгууллагууд хүргүүлэх буюу олон нийтэд хүргэнэ.
- 3.3 Олон нийтэд түгээвэл зохих мэдээллийг олон нийтэд тараах хугацаа, арга замыг компанийн ТУЗ, эсвэл Гүйцэтгэх удирдлага сонгож, хариуцах ажилтныг томилно.
- 3.4 Бусад мэдээллийг компанийн Гүйцэтгэх удирдлага, холбогдох алба, хэлтсүүд боловсруулан компанийн Олон нийттэй харилцах алба хариуцан олон нийтэд хүргэнэ.

#### **Дөрөв. Бусад**

- 4.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомж, компанийн дотоод журмандаа заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 4.2 Аливаа мэдээллийн үнэн зөвийг уг мэдээг боловсруулсан болон хянасан албан тушаалтан хариуцна.
- 4.3 Энэхүү журмыг зөрчсөнөөс холбогdon үүсэх хохирлыг хариуцлага ногдуулсан эсэхээс үл хамааран буруутай этгээд нөхөн төлж барагдуулна.